

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2015 оны ...дугаар
сарын ...ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030 он/ батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1 дэх хэсгийг үндэслэн Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал"-ыг 1 дүгээр, төрөөс баримтлах эдийн засаг, нийгэм, ногоон хөгжлийн тэргүүлэх чиглэлийн бодлогын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Ч.Сайханбилэг/-т үүрэг болгосугай:

1/энэ тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан төрөөс баримтлах бодлогыг 2016 оны 4 дүгээр улиралд багтаан шинэчлэн болон шинээр боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авах;

2/урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал батлагдсантай холбогдуулан Улсын Их Хурлаас батлан гаргасан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, үндсэн чиглэл, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж, шинэчлэн боловсруулах, батлах;

3/урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусган үе шаттайгаар хэрэгжүүлэх;

4/урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх байнгын бүтэц, тогтолцоог бий болгох;

5/урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн байдалд хоёр жил тутам хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороонд танилцуулж байх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн байгуулалтын байнгын хороо /А.Бакей/-нд даалгасугай.

4.Монгол Улсын Их Хурлын сонгуульд оролцох улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөр нь Монгол Улсын урт

хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэнийг Үндэсний аудитын газар хянан баталгаажуулсаны дараа улс төрийн нам, эвсэл, бие даан нэр дэвшигчийг бүртгэж байхыг Сонгуулийн ерөнхий хороо /Ч.Содномцэрэн/-нд даалгасугай.

5.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалыг батлах тухай” Улсын Их Хурлын 1996 оны 5 дугаар сарын 3-ны өдрийн 26 дугаар тогтоол, “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлогыг батлах тухай” Улсын Их Хурлын 2008 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 12 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

Улсын Их Хурлын 2015 оны ...дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

**МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /2016-2030 ОН/**

**НЭГ. МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ
БАРИМТЛАЛЫН АЛСЫН ХАРАА**

Эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэх Үндсэн хуулийн заалтыг иш үндэс болгон *Монгол Улс 2030 онд эдийн засгийнхаа өсөлтөөр бүс нутгаа тэргүүлж, нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн, даяаршсан зах зээлд тогтвортой өсч байгаа олон салбартай, нээлттэй эдийн засагтай, нийгмийн хүрээнд орлогын тэгш бус байдлыг арилгаж, ядуурлаас бүрэн ангид, чинээлэг дундаж давхарга даваймгалсан, улс орноо алсын хараатай бодлогоор хөгжүүлдэг хариуцлагатай ардчилсан засаглалтай, боломжийг иргэн бүрт ижил олгож, бүтээлч үйл ажиллагааг дэмждэг, шударга өрсөлдөөнд тулгуурласан бизнесийн тунгалаг орчинтой, унаган байгаль, экологийн тэнцвэрийг хадгалсан ногоон хөгжлийг эрхэмлэсэн улс болгох Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлал /2016-2030 он/ (цаашид “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал” гэх)-ыг Монгол Улсын Их Хурлаас нийт ард түмэндээ хүргэж байна.*

**ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫГ
ХЭРЭГЖҮҮЛСНЭЭР 2030 ОНД:**

1. Дунд орлоготой орнуудыг тэргүүлэгч улс орнуудын эгнээнд хүрнэ. Эдийн засгийн жилийн дундаж өсөлт 2016-2030 онд 6.6 хувиас доошгүй байна. Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого 17,500 америк долларт хүрнэ.
2. Орлогын тэгш бус байдлыг багасгаж, орлогын тэгш бус байдлын үзүүлэлтийг 30-д хүргэн бууруулж, нийт хүн амын 80 хувь нь чинээлэг дундаж давхаргын ангилалд багтсан байна.
3. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.
4. Монгол хүний эрүүл, урт удаан амьдрах нөхцөлийг хангаж, дундаж наслалтыг 78-д хүргэнэ.

5. Хүний хөгжлийн өндөр үзүүлэлт бүхий улс орнуудын эгнээнд багтаж, эхний 70 орны нэг болно.
6. Төсвийг алдагдалгүй болгож, хуримтлал үүсгэх замаар 2017-2024 онуудад төлөх Засгийн газрын өрийг барагдуулж, эдийн засгийн тогтвортой өсөлтийн нөхцлийг хангана.
7. Ногоон хөгжлийн зорилтыг хэрэгжүүлж, ногоон эдийн засгийн үзүүлэлтээр дэлхийн эхний 30 орны нэг болно.
8. Байгаль орчныг хамгаалах хүрээнд ойжуулалтыг нэмэгдүүлж, цөлжилтийг бууруулж, усны нөөцийг үр ашигтай ашиглах зорилтыг хэрэгжүүлнэ. Байгаль орчны багц үзүүлэлтээр дэлхийд эхний 90 орны нэг болно.
9. Засаглалын хүрээнд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид, төрийн алба нь цэвэр тунгалаг, хариуцлагатай, ардчилсан иргэний нийгмийн засаглал төлөвшинэ.
10. Бизнесийн орчныг сайжруулж, бизнес эрхлэлтийн үзүүлэлтээр дэлхийд эхний 40 орны нэг болно.

**ХОЁР. МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /2016-2030 ОН/- ЫН ҮР ДҮНГ
ИЛЭРХИЙЛЭХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД**

Монгол Улсын урт хугацааны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг хэрэгжүүлснээр эдийн засаг, нийгмийн хөгжилд гарах үр дүн, өөрчлөлтийг дараах 25 үндсэн үзүүлэлтээр тодорхойлох бөгөөд хэрэгжилтийн явцыг үнэлсний үндсэн дээр үзэл баримтлалын хэрэгжилтийг сайжруулах арга хэмжээ авна.

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2014 он)	Зорилтот түвшин (2030 он)
1	Эдийн засгийн жилийн дундаж өсөлт	хувиар	7.8	6.6 (2016-2030 онуудын дундаж)
2	Нэг хүнд ногдох үндэсний нийт орлого	ам.доллар	4,280	17,500
3	Хүний хөгжлийн үзүүлэлт	эзлэх байраар	103	70
4	Дундаж наслалт	жилээр	69.8	78
5	Жини коэффициент	оноогоор	36.5	30
6	Ядуурлын түвшин	хувиар	21.6	0

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин (2014 он)	Зорилтот түвшин (2030 он)
7	Инновацийн хөгжлийн үзүүлэлт	эзлэх байраар	67	45
8	Хүнсний баталгаат байдлын үзүүлэлт	эзлэх байраар	60	35-40
9	Ногоон эдийн засгийн үзүүлэлт	эзлэх байраар	60	30
10	Өрсөлдөх чадварын үзүүлэлт	эзлэх байраар	104	70
11	Эдийн засгийн эрх чөлөөний үзүүлэлт	эзлэх байраар	96	60
12	Засаглалын үзүүлэлт	эзлэх байраар	50-55	65-70
13	Бизнес эрхлэлтийн үзүүлэлт	эзлэх байраар	56	40
14	Байгаль орчны багц үзүүлэлт	эзлэх байраар	111	90
15	Нийгмийн даатгалд хамрагдсан хүн амын эзлэх хувь	хувиар	34%	100%
16	1 000 амьд төрөлт дэх нялхсын эндэгдлийн түвшин	промилиэр	15.1	0
17	100 000 амьд төрөлт дэх эхийн эндэгдлийн түвшин	промилиэр	30.6	20
18	ЕБС-ийн анги дүүргэлт (улсын дундаж)	хүүхдийн тоогоор	27.3	20
19	Олон улсын худалдааны хорио цээрт нээлттэй болсон газар нутгийн эзлэх хувь	хувиар	0	60%
20	Цөлжилтөд өртсөн газар нутгийн эзлэх хувь	хувиар	78.2%	68%
21	Монгол Улсад аялах гадаад жуулчдын тоо	сая.хүн	0.392	2.0
22	Цахилгаан эрчим хүчний найдвартай эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувиар	89%	100%
23	Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	хувиар	17%	50%
24	ДНБ-д боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувь	хувиар	10.6%	30%
25	Гол нэр, төрлийн шатахууны хэрэгцээг дотоодын эх үүсвэрээс хангах хувь	хувиар	0	100%

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ЗОРИЛТУУД

3.1.ЭДИЙН ЗАСГИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Өнөөгийн эдийн засгийн өсөлтийн гол тулгуур болсон уул уурхайн салбарын экспорт, төсөвт эзлэх хувийг харгалзан цаашид ч тогтвортой хөгжүүлэхийн зэрэгцээ, экспортын шинэ салбар, түүхий эд боловсруулах аж үйлдвэрийн хөгжлийг дэмжих, хөдөө аж ахуйг хөгжүүлэх нь нэн чухал болж байна.

ХАА-г эрчимжүүлж, уламжлалт мал аж ахуйн болон тариалангийн салбарт технологийн дэвшилийг өргөнөөр нэвтрүүлэх, хүн амын хүнсний үндсэн хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангах, дэлхийн зах зээлд Монголын органик бүтээгдэхүүний брэндийг бий болгож, экспортлох шаардлагатай байна.

Аж үйлдвэрийн салбарт түүхий эдийг боловсруулан нэмүү өртөг шингээсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих таатай орчин бүрдүүлэх нь чухал юм.

Аялал жуулчлал нь ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн суурь салбар болохын хувьд Монголын унаган байгалийн хосгүй газруудыг сурталчлах, аялал жуулчлалын төрөл, дэд бүтэц, зохион байгуулалт, үйлчилгээг сайжруулан ирэх жуулчдын тоог нэмэгдүүлнэ.

Дэд бүтцийн хувьд эрчим хүч, түлш шатахууны хангамжийн дотоодын найдвартай эх үүсвэрийг бий болгох, цаашид эрчим хүчний экспортыг нэмэгдүүлэх шаардлагатай. Ингэснээр эдийн засгийн салбаруудын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлж, экспортыг хөгжүүлэх, олон төрлийн эх үүсвэртэй болох боломж бүрдэнэ.

Эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах макроэдийн засаг, салбарын хөгжлийн бодлого нь дараах гол зарчмуудад тулгуурлана:

Макро эдийн засгийн бодлогын суурь зарчмууд

- Урт хугацааны эдийн засгийн дундаж өсөлтийг 6.6 хувиас доошгүй байлгах,
- Төсвийн тэнцлийн зохистой харьцааг чанд баримтлах, ДНБ-д эзлэх төсвийн нийт зарлага /улсын нэгдсэн төсөв болон Хөгжлийн банкны санхүүжилтийг бүхэлд нь тооцсоноор/-ыг 2020 онд 35 хувь, 2030 он гэхэд 30 хувь хүртэл бууруулах,

- Нэгдсэн төсвийн тэнцэлийг цаашид алдагдалгүй байхаар батлан мөрдөх, уул уурхайн салбарын орлогыг оруулалгүй тооцсон төсвийн тэнцлийн алдагдалын ДНБ-нд эзлэх хувийг 2020 онд 15 хувь, 2025 онд 10 хувь хүртэл бууруулах,
- Өрийн дээд хязгаарыг чанд сахин мөрдөж ажиллах, гадаад зах зээл дэх Монгол улсын зээлжих зэрэглэлийг тогтмол дээшлүүлэхэд чиглэсэн бодлогыг хэрэгжүүлэх,
- Гадаад зах зээлийн болон түүхий эдийн үнэ ханшийн хэлбэлзэлээс сэргийлэх бодлогыг баримталж, хуримтлалын санг бий болгон арвижуулах,
- Гадаад валютын нөөцийн зохистой хэмжээг байнга бүрдүүлж байх,
- Төлбөрийн тэнцэлийг алдагдалгүй төлөвлөн хэрэгжүүлэх, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг хангаж, инфляцийг тогтвортой, нам түвшинд барих,
- Банк, санхүүгийн тогтолцооны урт хугацааны тогтвортой, эрсдэлгүй, найдвартай байдлыг чанд хангаж, хөгжлийн бодлогын зорилтод нийцсэн зээл, хүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж байх,
- Гадаад, дотоод зах зээлийн эрсдэл, нөлөөллийг байнга судалж, учирч болох үр дагавараас урьдчилан сэргийлэх бодлогыг мөрдөх,
- Олон улсын эдийн засгийн хамтын ажиллагааны байгууллага, санаачлагуудад нэгдэж, эдийн засгийн түншлэл, чөлөөт худалдааны хэлэлцээрүүдийг байгуулж, бүс нутгийн шинжтэй томоохон төслүүдийг хэрэгжүүлэх,
- Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхдээ төр хувийн хэвшлийн түншлэлийн зарчимд тулгуурлан, олон улсын байгууллага болон гадаадын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийг түлхүү ашиглаж, олон улсын санхүү, эдийн засгийн байгууллагуудтай бодлого, үйл ажиллагааны хувьд идэвхтэй хамтрах.

Салбарын хөгжлийн зорилтыг хангах зарчмууд

- Эдийн засгийг төрөлжүүлж, эрдэс баялагийн бус бүтээгдэхүүний экспортыг урамшуулан хөгжүүлэх бодлогыг хэрэгжүүлэх,
- Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, боловсрол, шинжлэх ухаан, инновацийн ололтыг экспортын гол салбаруудад кластер маягаар холбож хөгжүүлэх,
- Экспортод гарч байгаа шинэ нэр төрлийн бүтээгдэхүүний урт, дунд хугацаанд зах зээлд тогтвортой байх, тэсвэрлэх чадварыг сайжруулахад чиглэсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх,
- Улсын болон хувийн хэвшлийн гадаад дахь хөрөнгө оруулалт, бизнесийн үйл ажиллагааг дэмжин урамшуулах бодлого баримтлах,
- Технологи, инноваци шингэсэн шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжин урамшуулах бодлогыг хэрэгжүүлэх,

- Үйлдвэрлэл, үйлчилгээний стандартыг хүний эрүүл, аюулгүй амьдрах орчинг хангахуйц түвшинд хүргэх, ногоон хөгжлийн зорилтод нийцүүлэн шинэчлэн баталж, мөрдүүлэх,
- Эрдэс баялгийн томоохон ордуудыг аж ахуйн эргэлтэд оруулах, нэмүү өртөг шингээх замаар бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэх, хувийн болон улсын зардлаар хийх геологийн хайгуулыг нэмэгдүүлэх,
- Газрын зураглалыг боловсронгуй болгох замаар уул уурхайн нөөцийг нэмэгдүүлэх, одоо ашиглаж байгаа ордуудын дэд бүтцийг сайжруулж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулна.

3.1.1.Хөдөө аж ахуйн салбар

Зорилт 1. Бэлчээрийн малын удмын санг хадгалж, сүргийн бүтцийн зохистой харьцааг бүрдүүлж, малын эрүүл мэнд, эрсдэл даах чадварыг сайжруулах, мал амьтны эрүүл мэндийн хяналт, үйлчилгээнд олон улсын стандартыг үе шаттайгаар нэвтрүүлэн, хөдөө аж ахуйн бүтээмжийг нэмэгдүүлэн олон улсын зах зээлд гаргана.

-Үе шат 1- (2016-2020): Нийт мал сүргийн бүтцийг зохистой болгох, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 10-аас доошгүй хувийг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын өвчингүй тайван байдлын статусаар баталгаажуулан, мах, махан бүтээгдэхүүнийг хөрш орнуудын зах зээлд гаргах хэмжээг дорвитой нэмэгдүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Нийт мал сүргийн бүтцийг зохистой болгох, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 30 аас доошгүй хувийг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын өвчингүй тайван байдлын статусаар баталгаажуулан, мах, махан бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд гаргах.

-Үе шат 3- (2026-2030): Нийт мал сүргийн бүтцийг зохистой болгох, Монгол Улсын нутаг дэвсгэрийн 60 –аас доошгүй хувийг Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын өвчингүй тайван байдлын статусаар баталгаажуулан, олон улсын зах зээлд гаргах мах, махан бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах.

Зорилт 2. Хүн амын төвлөрөл, зах зээлийн эрэлтийг харгалзан эрчимжсэн мал аж ахуйг түлхүү хөгжүүлж, мах, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг 3 хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 150.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулах.

-Үе шат 2- (2021-2025): Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг 5 хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 200.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулах.

-Үе шат 3- (2026-2030): Нийт мал сүрэгт өндөр ашиг шимт мал, амьтны эзлэх хувийг 8 хувьд хүргэж, эрчимжсэн мал аж ахуйд цэвэр үүлдрийн үхрийн тоог 300.0 мянган толгойд хүргэх, гахай, тахианы аж ахуйн тоог нэмэгдүүлж, импортын хэмжээг бууруулах.

Зорилт 3. Газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэн хөгжүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Газар тариалангийн үйлдвэрлэлд тэг технологи нэвтрүүлэх ажлын явцыг 70 хувьд, усалгааны шинэ хэмнэлттэй технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 65 мян.га-д, элит сортын үрийн хангамжийг 75 хувьд хүргэх, хүчтэй элэгдэлд орсон талбайн хувийн жинг 57 хувьд хүртэл бууруулах.

-Үе шат 2- (2021-2025): Газар тариалангийн үйлдвэрлэлд тэг технологи нэвтрүүлэх ажлын явцыг 85 хувьд, усалгааны шинэ хэмнэлттэй технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 100 мян.га-д, элит сортын үрийн хангамжийг 90 хувьд хүргэх, хүчтэй элэгдэлд орсон талбайн хувийн жинг 55 хувьд хүртэл бууруулах.

-Үе шат 3- (2026-2030): Газар тариалангийн үйлдвэрлэлд тэг технологи нэвтрүүлэх ажлын явцыг 90 хувьд, усалгааны шинэ хэмнэлттэй технологийг нэвтрүүлэн, усалгаатай тариалангийн талбайг 120 мян.га-д, элит сортын үрийн хангамжийг 100 хувьд хүргэх, хүчтэй элэгдэлд орсон талбайн хувийн жинг 50 хувьд хүртэл бууруулах.

Зорилт 4. Малчин өрх, хот айлын аж ахуй эрхлэлтийг дэмжин, орчин үеийн техник, технологи, эрчим хүчээр хангаж, үйлдвэрлэл тогтвортой эрхлэх санхүү, эдийн засаг, эрх зүйн нөхцөлийг бүрдүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Малчдын 50 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Малчдын 75 хүртэл хувийг өрхийн аж ахуй эрхлэхэд нь хүрэлцэхүйц чадалтай цахилгааны эх үүсвэр, техник, технологиор хангах, лизинг, хөнгөлөлттэй зээл болон бусад төрлийн санхүүгийн дэмжлэг үзүүлэх, малчин

өрхийн бэлтгэсэн бүтээгдэхүүнийг зах зээлд нийлүүлэх оновчтой тогтолцоог бий болгох.

-Үе шат 3- (2026-2030): Малчин өрх бүр өрхийн аж ахуй эрхэлж, бизнесийн тогтвортой орлоготой болсон байх.

3.1.2. Аялал жуулчлал

Зорилт 1. Монгол Улс олон улсын нүүдлийн соёл, аялал жуулчлалын төв болно.

-Үе шат 1- (2016-2020): Байгаль, соёлын өвийн үйлдвэрлэл, үзмэрүүдийн голлох төвүүдэд жуулчлалын дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, олон улсын тавцанд Монголын аялал жуулчлалын имижийг бүрдүүлэх, гадаадын жуулчдын тоог 1.0 саяд хүргэх.

-Үе шат 2- (2021-2025): Бүсийн хэмжээнд олон улсын аялал жуулчлалын замналд нэгдэх, дэд бүтэц, үйлчилгээний чанарыг сайжруулах, аялал жуулчлалын олон төрөл, улирлын чанартай аялал жуулчлалыг хөгжүүлэх, Монголын нүүдлийн соёл, аялал жуулчлалын олон улсын сурталчилгааг тасралтгүй сайжруулах, гадаадын жуулчдын тоог 1.5 саяд хүргэх.

-Үе шат 3- (2026-2030): Нүүдлийн соёл, аялал жуулчлалын Монгол брэндийг дэлхийд сурталчлан, аялал жуулчлалаас орох орлогыг нэмэгдүүлэн, гадаадын жуулчдын тоог 2.0 саяд хүргэх.

3.1.3. Аж үйлдвэрийн салбар

Зорилт 1. Аж үйлдвэрлэлийг дэвшилтэт техник, технологи, инновацид суурилан хөгжүүлж, бүтээмжийг нэмэгдүүлэх.

-Үе шат 1- (2016-2020): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 15 хувьд хүргэж, бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан үйлдвэрлэлийн тогтолцоог бий болгох, экспортыг дэмжих, импортыг орлох аж үйлдвэрийн бодлогыг баримтлах.

-Үе шат 2- (2021-2025): Нийт экспортод боловсруулах үйлдвэрлэлийн эзлэх хувийн жинг 25 хувьд хүргэж, импортыг орлуулах, бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан үйлдвэрлэлийн шинэ салбаруудыг

хөгжүүлж, дундаж ба өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, дахин боловсруулах үйлдвэрүүдийг дэмжин хөгжүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Бүтээмжийг нэмэгдүүлэх, дэвшилтэт техник, технологи, инновацид суурилсан боловсруулах үйлдвэрлэлийг бий болгож, дундаж ба өндөр технологийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, боловсруулах үйлдвэрлэлийн нийт экспортод эзлэх хувийн жинг 50-д хүргэх.

Зорилт 2. Хүнсний үйлдвэрлэлд өндөр түвшний технологи нэвтрүүлж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангаж, иргэдийг эрүүл, баталгаат хүнс хэрэглэх нөхцлийг бүрдүүлнэ.

-Үе шат 1 -(2016-2020): Хот, суурин газрын бүсэд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэлийн кластер хөгжүүлэх эхлэлийг тавьж, хүн амын хэрэгцээнд нийлүүлж байгаа махны 30 хувийг, сүүний 40 хувийг үйлдвэрлэлийн аргаар боловсруулах, хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр хангах.

-Үе шат 2- (2021-2025): Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр хангах, шинжлэх ухааны өндөр түвшний технологи нэвтрүүлж, гадаад зах зээлд “монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүн гаргах.

-Үе шат 3- (2026-2030): Хүн амын хэрэгцээг эрүүл баталгаатай хүнсээр бүрэн хангах, олон улсын зах зээлд “монгол брэнд” хүнсний бүтээгдэхүүний нэр, төрлийг нэмэгдүүлэх.

Зорилт 3. Химийн аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлж, гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг олон улсын стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр бүрэн хангана.

-Үе шат 1- (2016-2020): Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 20 хувийг Евро 4 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс, алт хайлуулах, улмаар дагалдах химийн бодис болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээний 70 хувийг Евро 5 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр хангах, зэс, алт хайлуулах, улмаар дагалдах химийн бодис болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Гол нэр төрлийн шатахууны хэрэгцээг Евро 5 стандартад нийцсэн дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүнээр 100 хувь хангах, зэс, алт

хайлуулах, улмаар дагалдах химийн бодис болон бордооны үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

3.1.4. Уул уурхайн салбар

Зорилт 1. Геологийн салбарын хөгжлийг дэмжинэ.

-Үе шат 1 – (2016-2020): Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг эрчимжүүлэх, судалгааны ажлын арга, аргачлал, зааврыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн заавар, аргачлалтай уялдуулан шинэчлэн боловсруулах, Монгол Улсын нутаг дэвсгэрийг геологийн 1:200000 масштабын зураглалд бүрэн хамруулан, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар нийт нутаг дэвсгэрийн 40 хувийг хамруулах,

-Үе шат 2- (2020-2025): Геологи, геохими, геофизикийн бүх төрлийн судалгааны ажлыг үргэлжлүүлэх, геомэдээллийн нэгдсэн санг бий болгож, ашигт малтмал хайгуулын салбарт хөрөнгө оруулалтын таатай орчныг бий болгох, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын хэмжээнд 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар нийт нутаг дэвсгэрийн 50 хувийг хамруулах,

-Үе шат 3- (2026-2030): Ашигт малтмалын эрдсийн хуримтлал бүхий талбайд нарийвчилсан эрлийн ажлыг хийх, ашигт малтмалын хэтийн төлөв бүхий хүдрийн бүс, сав газрын хэмжээнд 1:50000 масштабын геологийн зураглал, ерөнхий эрлийн ажлаар нийт нутаг дэвсгэрийн 60 хувийг хамруулах.

Зорилт 2. Уул уурхайн салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ.

-Үе шат 1 – (2016-2020): Хөрөнгө оруулалтын орчинг боловсронгуй болгож, зам, тээвэр, цахилгаан хангамжийн найдвартай эх үүсвэр, дэд бүтцийг бий болгож, тээврийн өртгийг бууруулан, Говийн бүсийн ашигт малтмалын орд газар, үйлдвэрлэлийн усан хангамжийн найдвартай эх үүсвэрийн талаар судалгаа хийх,

-Үе шат 2- (2020-2025): Зам, тээврийн дэд бүтэцтэй уялдуулан хилийн боомтын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлэн, Говийн бүсийн томоохон хүчин чадал бүхий цахилгаан станц байгуулж, усан хангамжийн найдвартай эх үүсвэрийн төслүүдийг хэрэгжүүлж, уул уурхайн томоохон төслүүдийн үйлдвэрлэлийн бүрэн хүчин чадлыг эзэмших.

-Үе шат 3- (2026-2030): Төмөр замын нэмэлт гарц, тээвэрлэлтийн ложистик сүлжээг бий болгох замаар уул уурхайн экспортын бүтээгдэхүүнийг гуравдагч зах зээлд хүргэж өрсөлдөх чадварыг дээшлүүлэх.

3.1.5. Эрчим хүч, дэд бүтцийн салбар

Зорилт 1. Эрчим хүчний хэрэгцээг дотоодын найдвартай, тогтвортой эх үүсвэрээр бүрэн хангаж, цахилгаан эрчим хүч экспортлоно.

-Үе шат 1- (2016-2020): Эрчим хүчний хэрэгцээнийхээ 85 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.

-Үе шат 2- (2021-2025): Эрчим хүчний хэрэгцээнийхээ 90 хувийг дотоодын эх үүсвэрээр хангах.

-Үе шат 3- (2026-2030): Цахилгаан эрчим хүчний цэвэр экспортлогч орон болох.

Зорилт 2. Сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчинд эзлэх хувийг нэмэгдүүлэх, эрчим хүчний шинэ эх үүсвэрүүдийг ашиглах бэлтгэлийг хангана.

-Үе шат 1- (2016-2020): Сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчинд эзлэх хувийг 20-д хүргэх, цөмийн эрчим хүч ашиглах бэлтгэл ажлыг хангах.

-Үе шат 2- (2021-2025): Сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчинд эзлэх хувийг 25-д хүргэх.

-Үе шат 3- (2026-2030): Сэргээгдэх эрчим хүчний нийт эрчим хүчинд эзлэх хувийг 30-д хүргэх.

Зорилт 3. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц зам, тээвэр, ложистикийн сүлжээг өргөжүүлэн хөгжүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр ложистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж, Ухаа худаг – Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт – Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Аж үйлдвэр, хөдөө аж ахуй, уул уурхайн салбарт түшиглэсэн тээвэр ложистикийн төвүүдийг барьж ашиглалтад оруулах, хоолойн тээвэр болон тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх, улсын чанартай авто замын сүлжээн дах хатуу хучилттай авто замын уртыг 800 км-ээр нэмэгдүүлж, Эрдэнэт –

Овоот, Богд хаан төмөр замыг барьж дуусгах, бүсүүдийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Тээвэр ложистикийн шинэ төвүүдийг хөгжүүлж, улсын болон олон улсын чанартай авто замын уртыг 470 км-ээр нэмэгдүүлж, бүсүүдийн төмөр замыг барьж дуусгах.

Зорилт 4. Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээнд нийцсэн, эдийн засгийн үр ашигтай, аюулгүй, ая тухтай бүх төрлийн тээврийн үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, аймаг болон томоохон сумдын нисэх буудлыг хөгжүүлэх, ерөнхий зориулалтын агаарын тээврийг хөгжүүлэх, Хөшигийн хөндийн олон улсын нисэх буудлыг барьж дуусгах.

-Үе шат 2- (2021-2025): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, үндэсний нисэхийн нөөц буудал байгуулах, агаарын тээвэрт чөлөөт өрсөлдөөнийг дэмжиж, Хөшигийн хөндийн нисэх буудлыг бүс нутгийн зангилаа төв болгон хөгжүүлэх, орчин үеийн технологид тулгуурласан нийтийн тээврийн шинэ тогтолцоог Улаанбаатар хотод бий болгох.

-Үе шат 3- (2026-2030): Гадаад, дотоод худалдааны тээврийн зардлыг бууруулах, хугацааг багасгах, үндэсний агаарын тээврийн сүлжээг хөгжүүлж бүс нутагт агаарын тээврийн транзит төвийг хөгжүүлэх.

Зорилт 5. Хүн амын нутагшилт, суурьшлын зохистой тогтолцоонд тулгуурлан хот байгуулалт, газрын харилцааны эрх зүйн орчныг боловсронгуй болгоно.

-Үе шат 1- (2016-2020): “Монгол Улсын хүн амын нутагшилт, суурьшлын хөгжлийн ерөнхий төсөл” боловсруулах, “Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол”-ыг үе шаттай хэрэгжүүлэх, аймгийн төвүүдийн хөгжлийн болон улс, аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тодотгол хийх.

-Үе шат 2- (2021-2025): Аж үйлдвэрийн хөгжлийн тэргүүлэх бүсүүдийг тогтоож, хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулан мөрдүүлэх, үндэсний орон зайн мэдээллийн дэд бүтцийг байгуулах, газар нутаг ашиглалтын мастер төлөвлөгөөг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд боловсруулж мөрдүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Хот, суурин газруудын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг үргэлжлүүлэн боловсруулж, мөрдүүлэх.

Зорилт 6. Хот суурин газрын бие даасан байдлыг хөгжүүлж, хот байгуулалтын томоохон төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэн зам харилцаа, инженерийн дэд бүтцийг барьж байгуулах, иргэдийн амьдрах эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлэх, дэлхийн жишигт нийцсэн ногоон хөгжлийн чиг баримжаагаар хот байгуулалтыг тогтвортой хөгжүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Хот байгуулалтын ногоон хөгжлийн стандартыг олон улсын жишигт нийцүүлэн боловсруулж, ногоон хөгжлийн загвар, хэм хэмжээнд нийцсэн, урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дэд бүтцийг хотуудад бий болгох.

-Үе шат 2- (2021-2025): Ногоон хөгжлийн загвар, хэм хэмжээнд нийцсэн урт хугацааны тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн дэд бүтцийг хот суурин газруудад бий болгох.

-Үе шат 3- (2026-2030): Олон улсын стандартад нийцсэн эрүүл, аюулгүй, тохилог орчныг бүрдүүлсэн хот суурин газруудыг хөгжүүлэх.

Зорилт 7. Харилцаа холбооны хамрах хүрээг өргөтгөх, орон нутагт өндөр хурдны сүлжээг нэвтрүүлэх, хэрэглээг нэмэгдүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөнө.

-Үе шат 1- (2016-2020): Нийт хүн амын 70 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, газар нутгийн байршлаас үл хамаарсан ижил үнэ, тарифыг мөрдөж, Ази, Европыг холбосон мэдээлэл дамжуулах өндөр хурдны сүлжээгээр дамжих мэдээллийн урсгалын хэмжээг 10 дахин нэмэгдүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Нийт хүн амын 90 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, хөдөө, орон нутгийн хүн амын 70 хувь нь өргөн зурвасын интернетийн үйлчилгээ ашиглах, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 50-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Нийт хүн амын 95 хувийг өндөр хурдны интернетийн сүлжээнд холбож, төрөөс иргэдэд чиглэсэн үйлчилгээний 85-аас доошгүй хувийг цахим хэлбэрт шилжүүлж, үндэсний хиймэл дагуул хөөргөн ашиглах.

3.1.6. Макро эдийн засгийн бодлого

Зорилт 1. Засгийн газрын дунд хугацааны өрийн стратегийг хэрэгжүүлж, өрийн бүтцийг өөрчлөн үйлчилгээний зардлыг бууруулах, өрийн дээд хязгаарыг чанд хатуу мөрдөнө.

-Үе шат 1- (2016-2020): Урт хугацаат зээл болон дахин санхүүжилтийн арга хэрэгсэлээр Засгийн газрын өрийн эргэн төлөлтийн дундаж хугацааг уртасгах; Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцааг үе шаттай бууруулж 55 хувьд хүргэх.

-Үе шат 2- (2021-2025): Урт хугацаат зээлийн төлбөрийн менежментийг оновчтой хийх Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцааг үе шаттай бууруулж 45 хувьд хүргэх.

-Үе шат 3- (2026-2030): Засгийн газрын өрийн өнөөгийн үнэ цэнээр илэрхийлэгдсэн үлдэгдлийн ДНБ-д харьцуулсан харьцааг үе шаттай бууруулж, 40 хувиас доош түвшинд барих.

Зорилт 2. Улсын төсвийн орлого, зарлагыг бодитой төлөвлөж, үр ашигтай, хэмнэлттэй, оновчтой удирдан зарцуулна.

-Үе шат 1- (2016-2020): Улсын төсвийн алдагдалыг ДНБ-ний 2 хувиас ихгүй байхаар төлөвлөх.

-Үе шат 2- (2021-2025): Улсын төсвийг алдагдалгүй төлөвлөж, хэрэгжүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Улсын төсвийг алдагдалгүй төлөвлөж, хуримтлалын сан үүсгэх.

3.2.НИЙГМИЙН ТОГТВОРТОЙ ХӨГЖИЛ

Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь эрүүл мэндийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, ядуурлын бүх төрөл, хэлбэрийг эцэс болгох, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.

Нийгмийн тогтвортой хөгжлийг хангах зарчмууд:

- Хөгжлийн үндсэн шалгуур үзүүлэлт нь хүний хөгжил байх,

- Иргэний болон насан туршийн боловсролын тогтолцоо нь Монгол хүний хөгжлийн нэг бүрэлдэхүүн хэсэг байх,
- Иргэдийн насан туршийн боловсрол эзэмших боломж нээлттэй байх,
- Эрүүл мэндийн үйлчилгээ нь иргэн, хамт олон, нийгмийн тэгш оролцоонд тулгуурласан, чанартай, хүртээмжтэй, шуурхай, санхүүгийн эрсдэлээс хамгаалагдсан байх,
- Хөдөлмөрийн чадвартай хүн амын ажил эрхлэлтийн түвшинг хамгийн өндөр түвшинд хүргэх чиглэлийг баримтлах,
- Нийгмийн хамгааллын үйлчилгээ нь баталгаатай, хүртээмжтэй, зорилтот бүлэгт чиглэсэн байх,
- Нийгмийн үйлчилгээнд зарцуулж буй улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг хүн амын тоотой уялдуулж төлөвлөнө.

3.2.1. Хүртээмжтэй өсөлтийн үндсэн дээр нийгмийн тэгш байдлыг хангах

Зорилт 1. Ядуурлын бүх төрлийг эцэс болгоно.

-Үе шат 1- (2016-2020): Ядуу, эмзэг бүлгийг орлогын байнгын эх үүсвэртэй болгох эдийн засаг, эрх зүйн орчинг бүрдүүлж, нийгмийн халамжийн тогтолцоог зорилтот бүлэг рүү чиглүүлэх, ядуурлын түвшинг 18 хувь хүртэл бууруулах.

-Үе шат 2- (2021-2025): Ядуу, эмзэг бүлгийн иргэдийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажиллах ур чадварыг дээшлүүлэх тогтолцоог сайжруулах, нийгмийн халамжийн үйлчилгээний үр өгөөжийг дээшлүүлэх, ядуурлын түвшинг нэг оронтой тоонд хүртэл бууруулах.

-Үе шат 3- (2026-2030): Ажлын байрны хүртээмжийг нэмэгдүүлж, ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргыг өргөжүүлж, хүн амын 80 хувьд хүргэх.

Зорилт 2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийн түвшинг бууруулна.

-Үе шат 1- (2016-2020): Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийн түвшинг 6 хувьд хүргэх хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжилтэй ажилчдыг бэлтгэн гаргах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг 100 тэрбум төгрөгөөс доошгүй түвшинд хүргэх.

-Үе шат 2- (2021-2025): Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийн түвшинг 4 хувьд хүргэх хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжилтэй ажилчдыг бэлтгэн гаргах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг 200 тэрбум төгрөгөөс доошгүй түвшинд хүргэх.

-Үе шат 3- (2026-2030): Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажилгүйдлийн түвшинг 3 хувьд хүргэх хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцүүлэн мэргэжилтэй ажилчдыг бэлтгэн гаргах, жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих сангийн хөрөнгийг 300 тэрбум төгрөгөөс доошгүй түвшинд хүргэх.

Зорилт 3. Үндэсний онцлог, хүн амын насны бүтцийн өөрчлөлтөд нийцүүлэн, амьдралын чанарыг дээшлүүлэхүйц нийгмийн даатгалын тогтолцоог хөгжүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Нийгмийн даатгалын (тэтгэвэрийн, ослын, хөдөлмөр эрхлэлтийн, тэтгэмжийн, эрүүл мэндийн даатгал) тогтолцооны шинэчлэлийг хэрэгжүүлж, сангуудын бие даасан байдал, удирдлага, засаглалыг сайжруулж, захиран зарцуулалт, санхүүгийн менежментийг ил тод болгох.

-Үе шат 2- (2021-2025): Нийгмийн даатгалын олон давхаргат тогтолцоог боловсронгуй болгох, хүн амыг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг үе шаттай, зах зээлийн нөхцөлтэй уялдуулан тогтоох.

-Үе шат 3- (2026-2030): Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн зохистой удирдлагыг хэрэгжүүлж, санг алдагдалгүй түвшинд хүргэх, даатгалын бүрэн бие даасан, хариуцлагатай, ил тод тогтолцоог бий болгох.

3.2.2. Эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй, шуурхай тогтолцоо

Зорилт 1. Урьдчилан сэргийлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэн, оношилгоо үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, хүн амын дундаж наслалтыг уртасгана.

-Үе шат 1- (2016-2020): Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог шинэчилж, урьдчилан сэргийлэх, зонхилон тохиолдох өвчнийг эрт илрүүлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, тандалт, эрт илрүүлэлтийн тогтолцоо, лавлагаа лабораторийг бэхжүүлж, хүн амын дундаж наслалтыг 71-д хүргэх.

-Үе шат 2- (2021-2025): Эрүүл мэндийн даатгалд хамрагддаг эмчилгээ, үйлчилгээний хамрах хүрээг нэмэгдүүлж, зонхилон тохиолдох өвчнийг эрт

илрүүлж, өвчлөл, нас баралтын эрсдэлт хүчин зүйлийг бууруулж, хүн амын дундаж наслалтыг 74-д хүргэх.

-Үе шат 3- (2026-2030): Эрүүл мэндийн үйлчилгээнд даатгалын, улсын төсвийн болон хувь хүний санхүүжилтийн зохистой харьцааг бий болгож, хүн амын эрүүл амьдралын хэвшлийг төлөвшүүлж, иргэн бүрийг эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд бүрэн хамруулж, нийт сумдыг хамарсан алсын зайн үндэсний сүлжээг бий болгож, хүн амын дундаж наслалтыг 78-д хүргэх.

Зорилт 2. Нөхөн үржихүйн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг дэмжих замаар сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эх, хүүхдийн эндэгдэл, хоол тэжээлийн дутагдалыг тогтвортой бууруулна.

-Үе шат 1- (2016-2020): Эхийн эндэгдлийн түвшинг 100,000 амьд төрөлтөд 30, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 15, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 13 болгож бууруулах.

-Үе шат 2- (2021-2025): Эхийн эндэгдлийн түвшинг 100,000 амьд төрөлтөд 25, тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 12, нялхсын эндэгдлийн түвшинг 1000 амьд төрөлтөд 8 болгож бууруулах.

-Үе шат 3- (2026-2030): Сэргийлж болох эх, хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлийг багасгаж, эхийн эндэгдлийн түвшинг 100,000 амьд төрөлтөд 20, сэргийлэх боломжтой тав хүртэлх насны хүүхдийн болон нялхсын эндэгдлийг арилгах.

Зорилт 3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчин, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлийн тархалт болон сэргийлж болох нас баралтыг хувь хүн, гэр бүл, хамт олон, байгууллагын идэвхитэй, оролцоотой нэгдмэл үйл ажиллагаанд тулгуурлан бууруулна.

-Үе шат 1- (2016-2020): Хүн амын хорт дадал, зуршлыг бууруулж, амьдрах орчин нөхцлийг сайжруулах, хүнсний бүтээгдэхүүнд чанар стандартыг чанд мөрдүүлэх, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 17.4, хорт хавдараас шалтгаалсан нас баралтыг 10.5 хүртэл бууруулах.

-Үе шат 2- (2021-2025): Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 16, хорт хавдараас шалтгаалсан нас баралтыг 9 хүртэл бууруулах.

-Үе шат 3- (2026-2030): 10000 хүн амд ногдох зүрх, судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтыг 14, хорт хавдараас шалтгаалсан нас баралтыг 8 хүртэл бууруулах.

Зорилт 4. Халдварт өвчний тандалт, сэргийлэлт, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг уян хатан, шуурхай зохион байгуулах чадавхийг тогтвортой бэхжүүлж, нэн шаардлагатай вакцинийг хүн бүрт хүртээмжтэй болгож халдварт өвчний тархалтыг бууруулна.

-Үе шат 1- (2016-2020): Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 98.5, 10 000 хүн амд вирүст гепатитын өвчлөлийг 3, сүрьеэгийн тохиолдлыг 14.4 болгон бууруулах.

-Үе шат 2- (2021-2025): Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99, 10 000 хүн амд вирүст гепатитын өвчлөлийг 2.5, сүрьеэгийн тохиолдлыг 14 болгон бууруулах.

-Үе шат 3- (2026-2030): Товлолт дархлаажуулалтын хамралтын хувийг 99.8, 10 000 хүн амд вирүст гепатитын өвчлөлийг 2, сүрьеэгийн тохиолдлыг 13 болгон бууруулах.

3.2.3.Мэдлэгт суурилсан нийгмийг хөгжүүлэх, ур чадвар бүхий иргэдийг төлөвшүүлэх

Зорилт 1. Хүүхэд бүрийг стандартын шаардлага хангасан сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулна.

-Үе шат 1: (2016-2020): Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд нийт хүүхдийн 90 хувийг хамруулах нөхцлийг бүрдүүлэх.

-Үе шат 2: (2021-2025): Сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоог 25 хүртэл бууруулах.

-Үе шат 3: (2026-2030): Сургуулийн өмнөх боловсролын нэг багшид ногдох хүүхдийн тоог 20 хүртэл бууруулах.

Зорилт 2. Олон улсад өрсөлдөх чадвартай ерөнхий боловсролын тогтолцоог хөгжүүлж, чанарыг баталгаажуулна.

-Үе шат 1-(2016-2020): Олон улсын боловсролын чанарын үнэлгээнд /PISA/ хамрагдах бэлтгэлийг хангаж, нийт ерөнхий боловсролын сургуулиудыг 2 ээлжээр хичээллэх боломжийг бүрдүүлэх, уламжлалт нүүдлийн ахуйд зохицсон боловсрол олгох хөтөлбөр боловсруулж, нэвтрүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Олон улсын боловсролын чанарын үнэлгээнд хамрагдах, нийт ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 2-р ээлжинд хичээллэх сургуулийн тоог 30 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дундажийг 25-аас илүүгүй байлгах.

-Үе шат 3- (2026-2030): Олон улсын боловсролын чанарын үнэлгээнд эзлэх байрыг 5-аар урагшлуулж, сургалтын лаборатори, тоног төхөөрөмж, техник хэрэгслээр бүх сургуулийг 100 хувь хангах, нийт ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын 2-р ээлжинд хичээллэх сургуулийн тоог 50 хүртэл хувиар бууруулах, анги дүүргэлтийг багасгаж, улсын дундажийг 20-иос илүүгүй байлгах.

Зорилт 3. Сургалт-судалгаа-үйлдвэрлэлийн түншлэлийг хөгжүүлж, шинжлэх ухаан, технологийн чадавхийг бэхжүүлнэ.

-Үе шат 1-(2016-2020): Олон улсын стандартад нийцсэн техник, технологийн боловсрол эзэмших шаталсан тогтолцоог бүрдүүлэх /МСҮТ, коллеж, их дээд сургууль/.

-Үе шат 2-(2021-2025): Шинжлэх ухаан, технологийн кластер, парк байгуулж, татвар, хөрөнгө оруулалт, зээлийн таатай нөхцлөөр дэмжих, Монгол Улсын дөрвөөс доошгүй их сургууль Азийн шилдэг 200 их сургуулийн эгнээнд орсон байх.

-Үе шат 3-(2026-2030): Их сургуульд түшиглэсэн шинжлэх ухааны паркд суурилж шинжлэх ухаан, технологийн эко систем бүрдүүлж хөгжүүлэх.

3.3.НОГООН ХӨГЖИЛ

Байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тогтвортой байдлыг хадгалах замаар орчинд ээлтэй, хүртээмжтэй өсөлтийг бий болгон хүний амьдралын сайн сайхан байдлыг дээшлүүлж тогтвортой хөгжилд хүрэх урьтал нөхцлийг хангахад ногоон хөгжлийн зорилт оршино.

Ногоон хөгжлийн зорилтын зарчмууд:

- Нөөцийг хэмнэлттэй, үр ашигтай, зохистой ашиглах,
- Ногоон хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн салбарын бодлого, төлөвлөлтийг хийх,
- Цэвэр дэвшилтэт технологийг дэмжих,
- Ногоон өсөлтийг бий болгоход иргэдийн оролцоог хангах,

- Байгальд ээлтэй хандлага, зөв дадлыг төлөвшүүлнэ.

3.3.1. Усны нөөцийн нэгдсэн менежментийг төлөвшүүлж, хүн ам, үйлдвэрлэлийн усны хэрэгцээг хүртээмжтэй хангах

Зорилт 1. Усны нөөцийг хамгаалж, хомсдолоос сэргийлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 50-иас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, хур тунадас, гадаргын ус хуримтлуулах 2-оос доошгүй улсын хэмжээний томоохон усан сан байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 15 хувьд хийх.

-Үе шат 2- (2021-2025): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 55-иас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авч, Хэрлэн, Орхон, Сэлэнгэ зэрэг томоохон голуудыг түшиглэн усны нөөцийн цогцолбор төслүүдийг хэрэгжүүлэх, гадаргын усыг хуримтлуулах сангуудыг байгуулах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 23 хувьд хийх.

-Үе шат 3- (2026-2030): Усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийн 60-аас доошгүй хувийг тусгай хамгаалалтад авах, гидрогеологийн дунд масштабын зураглалыг газар нутгийн 30 хувьд хийх.

Зорилт 2. Эрүүл ахуйн шаардлагад нийцсэн ундны усан хангамж, ариун цэврийн байгууламжийн хүртээмжийг нэмэгдүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 80-д хүргэж, хүн амын 40 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамруулах.

-Үе шат 2- (2021-2025): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 85-д хүргэж, хүн амын 50 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамруулах.

-Үе шат 3- (2026-2030): Баталгаат ундны усаар хангагдсан хүн амын эзлэх хувийг 90-д хүргэж, хүн амын 60 хувийг сайжруулсан ариун цэврийн байгууламжид хамруулах.

3.3.2. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, сөрөг нөлөөллийг сааруулах, бага нүүрстөрөгч бүхий тогтвортой орчинг бүрдүүлэх

Зорилт 1. Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох үндэсний чадавхийг бэхжүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги боловсруулж, насан туршийн боловсролын хүрээнд иргэдийн дасан зохицох мэдлэг боловсролыг олгож эхлэх.

-Үе шат 2- (2021-2025): Уур амьсгалын өөрчлөлтөд дасах стратегийн хэрэгжилтийг хангаж, жишиг төслүүдийг хэрэгжүүлэх, насан туршийн боловсролын хүрээнд иргэдийн дасан зохицох мэдлэг боловсролыг өргөжүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Уур амьсгалын өөрчлөлт, газрын доройтлын үр дагаварыг бууруулах, насан туршийн боловсролын хүрээнд иргэдийн дасан зохицох мэдлэг боловсролыг тасралтгүй олгох.

Зорилт 2. Байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи нэвтрүүлэх, үйлдвэрлэл, хэрэглээнд нүүрстөрөгчийн ялгаралыг бууруулна.

-Үе шат 1- (2016-2020): Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих, нүүрс, занарыг шингэрүүлэх, хийжүүлэх дэвшилтэт технологи нэвтрүүлэх замаар хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 2 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, сертификат авсан аж ахуй нэгж, байгууллагын тоог 2 дахин нэмэгдүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөллийг сааруулах арга хэмжээг тогтвортой хэрэгжүүлж, хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 7 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, сертификат авсан аж ахуй нэгж, байгууллагын тоог 5 дахин нэмэгдүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Эдийн засгийн бүтцэд өндөр технологи, инноваци шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлж хүлэмжийн хийн ялгарлыг өнөөгийн төсөөллөөр тооцсон хэмжээнээс 14 хувиар бууруулах, байгаль орчны удирдлагын MNS ISO 14001 багц стандарт нэвтрүүлэхийг дэмжиж, сертификат авсан аж ахуй нэгж, байгууллагын тоог 10 дахин нэмэгдүүлэх.

Зорилт 3. Цаг агаарын аюулт үзэгдэл, байгалийн гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бэхжүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Байгалийн аюулт үзэгдэл, болзошгүй гамшгийг тандан судлах, урьдчилан мэдээлэх тогтолцоог бэхжүүлж, салбарын болон орон нутгийн

гамшгийн эрсдэлийн менежментийн тогтолцоог нэвтрүүлэх, гамшигтай тэмцэх үндэсний чадавхийг бэхжүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах ажлыг үндэсний хэмжээнд тогтмол зохион байгуулах нөхцлийг бүрдүүлэх, гамшигтай тэмцэх үндэсний чадавхийг хөгжүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Гамшгийн эрсдэл, хохирлыг бууруулах, гамшигтай тэмцэх үндэсний чадавхийг хөгжүүлэх.

3.3.3.Экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, орчны бохирдлыг бууруулах

Зорилт 1. Байгальд ээлтэй төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлж, байгалийн унаган төрхийг хамгаалж, экосистемийн үйлчилгээний тогтвортой байдлыг хадгална.

-Үе шат 1- (2016-2020): Байгальд ээлтэй төлөвлөлтийн тогтолцоог бүрдүүлэх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 25 хувьд, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.5 хувьд хүргэх.

-Үе шат 2- (2021-2025): Байгальд ээлтэй төлөвлөлтийн тогтолцоог хөгжүүлэх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 27 хувьд, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 8.7 хувьд тус тус хүргэх.

-Үе шат 3- (2026-2030): Байгальд ээлтэй төлөвлөлтийн тогтолцоог хэрэгжүүлэх, улсын тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээг 30 хувьд, ойжуулах, ойгоор бүрхэгдсэн талбайг нийт газар нутгийн 9.0 хувьд тус тус хүргэх.

Зорилт 2. Хот суурины ногоон байгууламжийн төлөвлөлтийг боловсронгуй болгож, хог хаягдлын менежментийг сайжруулна.

-Үе шат 1- (2016-2020): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 15 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 20 хувьд хүргэх.

-Үе шат 2- (2021-2025): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 25 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 30 хувьд хүргэх.

-Үе шат 3- (2026-2030): Хот суурины ногоон байгууламжийн эзлэх хувийг 30 хувьд хүргэж, хог хаягдлыг дахин боловсруулах хэмжээг нийт хог хаягдлын 40 хувьд хүргэх.

3.4.ЗАСАГЛАЛ, БИЗНЕСИЙН ОРЧИН

Урт хугацааны хөгжлийн бодлогыг амжилттай хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын дагуу улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг баталгаажуулж, батлан хамгаалах чадавхийг бэхжүүлж, гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааг бүх талаар хөгжүүлж, эдийн засгийн бие даасан байдал, экологийн тэнцвэрт хөгжлийг бататган засаглалыг сайжруулах, бизнесийн орчныг боловсронгуй болгох явдал юм.

Засаглал, бизнесийн орчны үндсэн зарчмууд:

- Иргэдийн оролцоо, төр, хувийн хэвшлийн түншлэлийг хангасан ил тод, хариуцлагатай засаглалыг бүх түвшинд төлөвшүүлэх,
- Бизнес эрхлэх орчинг сайжруулах,
- Гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын тэгш байдлыг хангаж, таатай орчинг бүрдүүлэх,
- Татварын тогтвортой орчныг бүрдүүлнэ.

Зорилт 1. Бизнес, улс төрийг ангид байлгах, засаглалын ил тод, шударга үйл ажиллагааг хангаж, эдийн засагт төрийн оролцоог эрс багасгах замаар авлигаас ангид орчинг бүрдүүлнэ.

Үе шат 1- (2016-2020): Хувийн өмчийн халдашгүй байдлыг баталгаажуулах, эдийн засаг дахь төрийн оролцоог багасгаж, бизнесийг улс төрөөс ангид байлгаж, бизнесийг өөрийн зарчмаар хөгжих хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх.

-Үе шат 2- (2021-2025): Хувийн өмчийн халдашгүй байдлыг бүрэн хангаж, засаглалын ил тод байдал бүрэн хангагдаж, авлигаас ангид бизнесийн орчныг бүрдүүлэх.

-Үе шат 3- (2026-2030): Авлигагүй эдийн засаг, бизнесийн орчинг төлөвшүүлэх.

Зорилт 2. Төсөв, санхүү, мөнгөний бодлогыг бизнесийн орчинг дэмжихэд чиглүүлж, үндэсний хэмжээний эрсдэлийн удирдлагын тогтолцоотой болох, өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих, бүс нутгийн хэмжээнд санхүүгийн төвийг үүсгэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.

-Үе шат 1- (2016-2020): Зохистой мөнгөний бодлогыг хэрэгжүүлж, үндэсний хэмжээний эрсдэлийн удирдлагын тогтолцоотой болох, өрсөлдөөнийг хөхиүлэн дэмжих, эдийн засаг дах төрийн хувь, оролцоог эрс багасгах.

-Үе шат 2- (2021-2025): Санхүүгийн шинэчлэл хийж, гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын улс төрийн эрсдэлийг арилгаснаар бизнесийн орчин, баталгаат байдлыг сайжруулж, бүс нутгийн хэмжээнд санхүүгийн төвийг үүсгэх.

-Үе шат 3- (2026-2030): Бүс нутгийн хэмжээнд санхүүгийн төв болон хөгжих.

**МОНГОЛ УЛС ҮҮРД ЦЭЦЭГЛЭН ХӨГЖИЖ, МОНГОЛ ХҮН БҮР ЭРҮҮЛ ЭНХ, ЭРДЭМ
БОЛОВСРОЛ БҮХИЙ АЗ ЖАРГАЛТАЙ АМЬДРАХ БОЛТУГАЙ.**

-----oO-----

**МОНГОЛ УЛСЫН УРТ ХУГАЦААНЫ
ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ /2016-2030 ОН/-ЫН ХҮРЭЭНД
ТӨРӨӨС БАРИМТЛАХ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГЭМ, НОГООН ХӨГЖЛИЙН
ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

Нэг. Улсын Их Хурлаар батлах тогтвортой хөгжилд хүргэх бодлого:

- 1.1. Хүний хөгжлийн бодлого (эрүүл мэнд, боловсрол, амьдрах орчин);
- 1.2. Шинжлэх ухаан, инновацийн бодлого;
- 1.3. Эрүүл хүнсний бодлого;
- 1.4. Ногоон хөгжлийн бодлого;
- 1.5. Хөдөө аж ахуйн хөгжлийн бодлого;
- 1.6. Үйлдвэржүүлэлтийн бодлого;
- 1.7. Дэд бүтцийн хөгжлийн бодлого;
- 1.8. Аялал жуулчлалын хөгжлийн бодлого;
- 1.9. Хариуцлагатай уул уурхайн бодлого.

-----oOo-----